

## Буриад дахь оросын үнэн алдартны сүмийн эрүүл мэнд-нийгмийн ажлын үйл ажиллагаа

Шурыгина Ю.Ю.<sup>1</sup>, Сугармаа М.<sup>2</sup>

<sup>1</sup>ОХУ, Зүүн сибирийн технологи, удирдлагын улсын их сургууль,

<sup>2</sup>АШУУИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль

E-mail: juliaju@mail.ru

Abstract

### Health and Social Work Activities of the Russian Orthodox Church in Buryatia

Shurygina Yu. Yu<sup>1</sup>., Sugarmaa M<sup>2</sup>.

<sup>1</sup>East Siberia State University of Technology and Management, Russia

<sup>2</sup>School of Public Health, MNUMS

E-mail: juliaju@mail.ru

Technologies of social and medical work to improve the social status of citizens and their health are used in various spheres of life. One of them is the work of the Russian Orthodox Church (ROC), which does a lot to preserve the health of the country's population, to help the sick, the disabled, the elderly and other needy groups. The article attempts to analyze the forms and methods of medical and social work carried out at churches in the Republic of Buryatia. The efficiency of the performed work is analyzed, the groups of the population who seek help in Orthodox churches are considered. Conclusions are drawn that medical and social technologies of work which are used by the Russian Orthodox Church, promote decrease in diseases of a narcological profile and abortions among the population. Also, medical and social work carried out by the Church increases the social function of the ROC and reduces social tension in society.

**Keywords:** medical and social work, alcoholism, drug addiction, abortion.

Pp. 57-59, Table 1., References 5

### Удиртгал

Христийн шашинд тусламж шаардлагатай бүх хүнд тэр дундаа өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу хүмүүст туслахыг чухалд үздэг. 2000 онд Оросын үнэн алдартны сүм (ОУАС) өөрийн үйл ажиллагааны чухал баримтын нэг болох «Оросын Үнэн Алдартны Сүмийн нийгмийн үзэл баримтлалын үндэс»-ийг баталсан [1]. Энэхүү үзэл баримтлалд нийгмийн асуудал болсон архидалт, хар тамхинд донтох, үр хөндүүлэх асуудлуудад ихээхэн анхаарал хандуулжээ. Эдгээр асуудлуудыг социаль буюу нийгмийн нөхцөлтэй холбоотой өвчлөлд хамааруулдаг. Эдгээр нь тухайн хүний ойр орчмын хүрээллийн нөлөөгөөр буюу нийгэм-эдийн засгийн асуудлуудтай холбоотой үүссэн байдаг. Архидалт, хар тамхины донтолт, үр хөндөлтөөс урьдчилан сэргийлэх ажлыг ОУАС-ийн сүмийн буяны болон нийгмийн үйлчилгээний хэлтэс хариуцан хийдэг. 2014 онд архианаас гарсныг баталгаажуулах архидалтаас хамгаалах ОУАС-ийн үзэл баримтлалын бичгийг гаргасан [2].

### Зорилго

Хүн амыг эрүүлжүүлэхэд ОУАС-ийн үзүүлж байгаа нөлөөллийг тодорхойлохыг зорилоо. Үүний тулд

Буриадын нутаг дэвсгэрт ОУАС-ийн эрүүл мэнд-нийгмийн ажлын технологийг тогтоох, тэдгээрийн үр ашгийг судлах, тусламж авахаар хандагсдын нийгмийн статусыг тогтоох зорилтыг тавилаа.

### Арга

Судалгааг хийхдээ системчилсэн судалгааны арга болон асуулгын аргыг ашиглав.

### Үр дүн

2003 онд Улаан-Үд хотод Үнэн алдартны соёл, соён гэгээрүүлэх «Воскресение» төвийг нээжээ. Төвийн гол үйл ажилагаа нь архи, тамхи, хар тамхи болон бусад төрлийн хамаарлаас ангижрах хүсэлтэй хүмүүст бодит тусламж үзүүлэхэд оршдог. Энэ зорилгоор «Воскресенье» төв эрүүлжих сургуулийг байгуулж, хөнөөлт хамаарлуудаас чөлөөлөх сургалтыг явуулдаг. Өнгөрсөн хугацаанд 1000 гаруй хүн сургалтыг дүүргэжээ. Сургалтад хамрагдсан сонсогчид нь нэгдүгээрт архи болон тамхины асуудалтай холбоотой мэдээллийг авдаг. Архины хамаарлын шинж тэмдгүүдийг танин мэдэж, ямар нэгэн хамаарал хэрхэн үүсэн бий болдог, тэр хамаарлыг бий болоход гэр бүл, орчин тойрон болон олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд хэрхэн

нөлөөлдгийг таниулдаг. Нэг жилийн дотор дунджаар архи болон бусад хамаарлаас ангижрахыг хүсэгчдийн 10 бүлэг байгуулагддаг.

Тамхинаас гарахыг хүсэгчид энэ сургалтад хамрагдах нь илүү байдаг бол хар тамхи болон тоглоомын донтонгууд бага ирдэг байна. Сургалтад хэрэглэдэг нэг технологи нь - өдөр бүрийнхээ үйлдлийг тэмдэглэх арга бөгөөд ингэснээр өөрсдийгөө эрүүл амьдрах аргад дасгалжуулдаг. Урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн сурагчид болон оюутнууд сургалтад хамрагддаг. Түүнээс гадна архичин болон хар тамхичдын гэр бүл, хамаатнуудыг сургалтад хамруулж хорт зуршилтай дотны хүнтэйгээ хэрхэн зөв харилцахыг заадаг. Эрүүлжих сургуульд хамрагдагсдын дунд сэдэвт цуглаан, уулзалт, уран зохиол-хөгжмийн үдэшлэг явуулж эрдэм шинжилгээний практикийн бага хурлуудыг зохион байгуулдаг. Гол тэмдэглэлт өдрүүдийн нэг нь бүх Оросын архигүй өдөр [3]. Энэ өдөр баярын үдэшлэг зохион байгуулж, зочид эрүүл архигүй байх өдрийн түүх болон эрүүлжих боловсролын үндсүүдтэй танилцаж, армреслинг буюу хүндийг өргөх төрөлд

хүчээ сорьдог. Хүүхдийн дунд төрөл бүрийн хөтөлбөр зохион байгуулж, баярын үдэшлэгийг цай ууж өндөрлөдөг. Үдэшлэгийн дараа загалмайн алхааг хийдэг.

Үнэн алдартны итгэлд үр хөндөлтийг хүний амьтаслах үйлдэлд буюу аймшигт гэмд тооцдог [4]. 2012 оноос анх «Надад амьдрал бэлэглээч» нэртэй байсан сан «Эх болох баяр хөөр» гэж нэрээ өөрчлөн Буриадад үйл ажиллагаа явуулж байна. Үүсгэн байгуулагдах үед тус сангийн гол зорилго нь үр хөндөлттэй тэмцэх явдал байсан бол 6 жилийн хугацаанд сангийн үйл ажиллагаа өргөжсөн байна. Сангийн үйл ажиллагаанд хэдэн төрлийн буяны хөтөлбөр болон хэд хэдэн үйл ажиллагааг хамардаг. Сангийн үндсэн технологи нь эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газруудад сэтгэл зүйчээр дамжуулан үр хөндөлтийн өмнөх зөвлөгөө хийгддэг ба жирэмслэлтээ хамгаалан үлдэх талаар эмэгтэйчүүдэд ойлгуулахыг зорилгоо болгодог. Түүнээс гадна эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газруудад зурагт байрлуулан үр хөндөлтийн уршиг, эх болохын жаргалыг мэдрүүлэх кино үзүүлдэг [5].

**Table 1. Performance indicators of the Fund for 2012-2017**

Year	2012	2013	2014	2015	2016	2017	In total
Consulted (person)	913	1188	1256	299	1845	2099	7600
The rejection of abortion (people)	81	108	156	39	172	250	806
The rejection of abortion (%)	8.9	9.0	12.42	13.04	9.3	11.9	10.6

Хүснэгтээс харахад үр хөндөлтийн өмнөх зөвлөгөө өгөх ажлын үр дүнгийн хувь өндөр биш 8,9-өөс 13,04 хүртэл хэлбэлзэж байгаа ч 6 жилийн дотор үр хөндүүлэхээс 806 эмэгтэйг хамгаалж чадсан нь чухал үзүүлэлт юм.

Улаан-Үд болон Буриадын бусад муж дүүргийн эмийн сангуудтай хамтран ажиллаж, жирэмсэн эсэхийг шалгах тест худалдан авахад үр хөндөлт хийлгэхгүй байхыг уриалсан сангаас гаргасан хуудсыг дагалдуулан олгож байна. Мөн амьдралын хүнд нөхцөлд байгаа эмэгтэйчүүдэд тусламж авах боломжийг олгох зорилгоор хуудсанд итгэлцлийн утасны дугаарыг бичсэн, уг утсаар холбогдсон олон хүүхэдтэй болон ядуу гэр бүлүүдэд зарим (хүнс, хувийн ариун цэврийн хэрэглэл, ахуйн химийн бараа, эм, хүүхдийн сүүн тэжээл, живх, тоглоом, хүүхдийн ор, тэрэг, хичээлийн хэрэгсэл, хувцас) тусламж үзүүлдэг. Энэ үйл ажиллагааны хүрээнд хандивлагчдыг татан оролцуулах, хүүхдийн эд хэрэгслийг хадгалах агуулах, савыг гаргах олон ажил хийгддэг. Хотын хэд хэдэн дэлгүүрт тусгай агуулахыг байрлуулсан ба оршин суугчид өөрсдийн хүсэлтээр хүүхдийн бараа болон хүнсийг хандив болгодог.

Сэдэвт брошюр, ухуулах хуудас, товхимол байршуулах зэрэг соён гэгээрүүлэх төслүүдийг зохион байгуулдаг. Эх, эцэг болох, гэр бүлийн үнэ цэнэ, үр хөндөлтийн уршиг зэрэг олон сэдвээр төрөл бүрийн видео бичлэг үзүүлэх болон лекц хийх замаар гэр бүлийн уламжлалт үнэлэмжийг дэлгэрүүлэх ажлыг тогтмолжуулдаг. Түүнээс гадна өнчин хүүхдийг үрчлэн авахыг сурталчлах ажлыг явуулдаг. 2017 онд залуучуудад зориулан 8015 хүнийг хамруулсан 246 лекц зохион байгуулжээ.

Сангийн дэргэд эмнэлэгт хэвтэж байгаа ганц бие хүмүүсийг эргэж тойрох, нийгмийн халамжийн «Доверие» (Итгэл) төвд байрлах ганц бие хөгшчүүд болон өнчин хүүхдүүдтэй уулзах, ядуу гэр бүлийн хүүхдэд болон орон гэргүй хүмүүст тусламж үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг «Нигүүслийн алба» (Служба Милосердия) нээгдсэн байна. Мөн сангаас «Отрада» хэмээх буяны үйл ажиллагааг нээсэн. Сан нь өдөр бүр гэр оронгүй 120-150 хүмүүст өдрийн халуун хоолоор үйлчилж байна.

Шинэ Брянь тосгонд жирэмсэн болон нярайлан эхчүүдэд зориулсан «Остров Надежды» (Найдварын арал) хэмээх нөхөн сэргээх төвийг Сангийн зүгээс

нээсэн байна. Амьдралын хүнд нөхцөлд орсон (төрөл төрөгсөдтэйгээ асуудалд орсон, нөхрийн дарамтад өртсөн, хүүхдээ тэжээн асрах боломжгүй гэх мэт), тусламж гуйсан эмэгтэйчүүдийг байршуулдаг байна. Нөхөн сэргээх энэ газар ногооны талбайтай тул эмэгтэйчүүд ногоо тарьж, тахиа тэжээдэг. Тус төв нь нэг дор 12-15 хүн хүлээн авах боломжтой, 3 жилийн хугацаанд 50 эмэгтэй үйлчлүүлсэн ба 19 хүүхэд төрсөн. Сангийн зүгээс «Амьдралын төлөө» авто уралдаан, «Жирэмсэн гоо үзэсгэлэнт эмэгтэй» зургийн үзэсгэлэн, ээж нарын болон хүүхдийн эрх хамгаалах өдөр зэрэг баярыг зохион байгуулдаг.

«Эх болох баяр хөөр» буяны сангийн үр дүнг үнэлэх зорилгоор 2018 оны 5 дугаар сард асуулгын аргаар социологийн судалгаа явуулсан. Судалгаанд тус Сангаас тусламж авсан 30 хүн хамрагдсан. Тусламж хүсэгчдийн дунд дээд боловсролтой хүн байгаагүй ба 60-аас дээш хувь нь огт ажилгүй эсвэл тогтмол орлогогүй хүмүүс байв. Асуулгад оролцогчдын талаас бага хувь нь албан ёсны гэр бүлтэй байв. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүд бүгд олон хүүхэдтэй байв. Тэдгээрийн дийлэнхи буюу 84 хувь хүнс, эм, гэр ахуйн химийн бүтээгдэхүүн, хүүхдийн тэжээл, живх, хувийн ариун цэврийн хэрэглэл, хүүхдийн бараа, хувцас, 70 хувь нь сэтгэл зүйн, 39 хувь нь хууль эрх зүйн тусламж хүртэж, 15 хувь нь ажил хөдөлмөрт зуучлуулж, 6 хувь орон сууцны асуудлаа шийдвэрлэжээ. Санд хандагсад бүгд тусламж авч, тэдгээрийн 50 хувь бүрэн үйлчилгээ авсан байна.

Эцэст дүгнэхэд Оросын Үнэн алдартны сүм нь төрөл бүрийн эрүүл мэнд-нийгмийн ажлын технологийг ашиглан архидалт, хар тамхины донтолт, үр хөндөлт зэрэг нийгмийн асуудлуудыг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна. Дээр дурдсан үйл ажиллагаа нь нийгэмд учрах дарамтыг багасгахад нөлөөтэй юм.

## Ном зүй

1. Ефлова, М. Ю. Опыт русской православной церкви по социальной инклюзии наркозависимых / М. Ю. Ефлова // Власть. – 2015. - № 6. – С. 103-106.
2. Основы социальной концепции русской православной церкви [Электронный ресурс]: Режим доступа к сайту: <http://www.patriarchia.ru/> (Дата обращения: 24.02.2016).
3. Разинкова, Т. Б. Участие русской православной церкви в борьбе с алкоголизмом и наркоманией / Т. Б. Разинкова // Российский следователь. – 2010. - № 9. – С. 12-14.
4. Новикова, Г.А. Социальные аспекты подростковой беременности / Г.А. Новикова, А.Г. Соловьев // Современные исследования социальных проблем: Медицина и здравоохранение. – 2013. - № 9. – С. 53-56.
5. Басов, Н. Ф. Церковная социальная помощь различным группам молодежи / Н. Ф. Басов // Вестник Костромского государственного университета им. Н. А. Некрасова. Серия гуманитарные науки. – 2013. - № 1. – С. 132-136.

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:  
Анагаах ухааны доктор, Профессор Д.Цэрэндагва*